

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ХОВД АЙМГИЙН СТАНДАРТ ХЭМЖИЛЗҮЙН ХЭЛТСИЙН 2020 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/92/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Гэрээт аудитор: Н.Батжаргал Утас: 70432545</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>

Агуулга

ХОВД АЙМГИЙН СТАНДАРТ ХЭМЖИЛЗҮЙН ХЭЛТСИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	0
1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН төгрөгөөр.....	5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН төгрөгөөр	6
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН төгрөгөөр	7
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	8
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	9
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН	10
3.АУДИТЫН ТАЙЛАН.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	14
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	14
1. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал	14
2. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал	14
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	15

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



2021.02.25 № 4/84
талай _____ -ны № _____ -т

СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
Б. ГОМБОСҮРЭН

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, бүтээгдэхүүн ажил үйлчилгээний баталгаажуулалт, стандартын салбар сан, сорьцын хяналт зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжээгүй, батлагдсан төсвөөс зардлын зүйл хооронд зөвшөөрөлгүйгээр шилжүүлэн зарцуулсан, тооцооллын зөрүүгээс авлага, өр төлбөр үүсгэсэн зэрэг зөрчлүүд нь Төсвийн

021020189

тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зэрэг эрх зүйн акттай нийцэхгүй, "үнэн зөв байх", "бодитой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х. БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН төгрөгөөр**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>18,058,561.00</u>	<u>33,365,793.05</u>
33	АВЛАГА	12,898,783.00	20,448,645.05
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	11,121,883.00	553,874.05
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,046,900.00	245,950.00
335	Бусад авлага	730,000.00	19,648,821.00
3351	Байгууллагаас авах авлага	730,000.00	6,430,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	13,218,821.00
35	БАРАА МАТЕРИАЛ	5,159,778.00	12,917,148.00
351	Түүхий эд материал	477,949.00	477,949.00
35110	Тусгай зориулалттай материал	477,949.00	477,949.00
354	Хангамжийн материал	4,681,829.00	12,439,199.00
35410	Бичиг хэргийн материал	1,398,824.00	2,574,344.00
35420	Аж ахуйн материал	3,223,005.00	8,478,355.00
35430	Сэлбэг хэрэгсэл	60,000.00	1,386,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>309,808,756.64</u>	<u>306,738,450.90</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	309,808,756.64	306,738,450.90
392	Биет хөрөнгө	302,608,756.64	299,538,450.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	294,612,490.00	294,612,490.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-4,663,044.76	-10,665,285.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	144,245,526.00	150,145,526.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	136,256,963.37	-138,964,239.09
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,634,399.30	9,634,399.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,908,665.17	-9,145,400.93
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,609,630.00	4,609,630.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-664,615.36	-688,668.86
393	Биет бус хөрөнгө	7,200,000.00	7,200,000.00
39301	Программ хангамж	772,500.00	772,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-772,500.00	-772,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,200,000.00	7,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>327,867,317.64</u>	<u>340,104,243.95</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>282,789.32</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	282,789.32
413	Өглөг	00.00	282,789.32
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	282,789.32
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>327,867,317.64</u>	<u>339,821,454.63</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	327,867,317.64	339,821,454.63
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	254,315,896.00	254,315,896.00
51101	Өмч: - төрийн	254,315,896.00	254,315,896.00
512	Хуримтлагдсан үр дүн	-35,177,886.94	-23,223,749.95
51210	Өмнөх үеийн үр дүн	-35,177,886.94	-33,318,505.97
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	10,094,756.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	108,729,308.58	108,729,308.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>327,867,317.64</u>	<u>340,104,243.95</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	280,720,123.00	255,380,296.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,584,623.00	69,065,296.00
120	Нийтлэг татварын бус орлого	41,584,623.00	69,065,296.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	41,584,623.00	69,065,296.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,319,623.00	68,231,296.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	435,000.00	834,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	239,135,500.00	186,315,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	239,135,500.00	186,315,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	239,135,500.00	186,315,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	292,681,428.26	245,285,539.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	292,681,428.26	245,285,539.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	228,384,284.26	221,651,211.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	133,680,778.00	146,109,761.19
210101	Үндсэн цалин	133,680,778.00	146,109,761.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,716,537.00	18,270,704.00
210201	Тэтгэврийн даатгал	11,369,305.00	12,424,079.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,336,808.00	1,461,656.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,069,448.00	1,169,326.00
210204	Ажилгүйдлийн даатгал	267,361.00	292,331.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,673,615.00	2,923,312.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,766,337.00	17,229,768.00
210301	Гэрэл, цахилгаан	10,799,671.00	11,207,968.00
210302	Түлш, халаалт	3,960,000.00	3,300,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,006,666.00	2,721,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,248,692.00	12,216,943.00
210401	Бичиг хэрэг	2,986,250.00	3,703,705.00
210402	Тээвэр, шатахуун	5,073,000.00	6,731,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,189,442.00	1,493,738.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	258,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	30,000.00
2105	Нормативт зардал	561,800.00	1,302,350.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	250,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	561,800.00	1,052,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,279,500.00	4,192,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	192,000.00
210604	Урсгал засвар	13,279,500.00	4,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,200,000.00	8,832,000.00
210702	Дотоод албан томилолт	9,200,000.00	8,832,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,116,000.00	2,141,380.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	220,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	800,000.00	104,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	500,000.00
210807	Газрын төлбөр	00.00	17,380.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	566,000.00	1,300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,814,640.26	11,356,305.74

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,622,300.00	936,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	997,000.00	1,450,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,195,340.26	8,970,305.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,297,144.00	23,634,328.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,220,400.00	18,655,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,620,400.00	18,085,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	570,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,076,744.00	4,979,028.05
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,076,744.00	4,979,028.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-11,961,305.26	10,094,756.02
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-11,961,305.26	10,094,756.02

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**төгрөгөөр**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	281,037,823.00	255,977,246.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,902,323.00	69,032,246.00
120	Нийтлэг татварын бус орлого	41,902,323.00	69,032,246.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	41,902,323.00	69,032,246.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,072,323.00	69,032,246.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	239,135,500.00	186,945,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	239,135,500.00	186,315,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	239,135,500.00	186,315,000.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	00.00	630,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	281,037,823.00	255,977,246.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	281,037,823.00	255,977,246.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	216,110,679.00	231,682,917.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	139,758,000.00	145,777,999.93
210101	Үндсэн цалин	96,411,615.00	102,585,786.45
210102	Нэмэгдэл	40,167,217.00	38,645,613.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,179,168.00	4,546,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,719,800.00	18,837,540.02
210201	Тэтгэврийн даатгал	11,527,800.00	13,006,340.02
210202	Тэтгэмжийн даатгал	1,048,000.00	1,457,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	838,500.00	1,166,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	209,500.00	291,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,096,000.00	2,915,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,766,337.00	22,929,768.00
210301	Гэрэл, цахилгаан	10,799,671.00	16,907,968.00
210302	Түлш, халаалт	3,960,000.00	3,300,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,006,666.00	2,721,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,667,542.00	10,057,963.00
210401	Бичиг хэрэг	900,000.00	1,799,963.00
210402	Тээвэр, шатахуун	4,500,000.00	5,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,189,442.00	1,500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	99,100.00	258,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	979,000.00	1,500,000.00

2105	Нормативт зардал	00.00	2,000,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,189,000.00	13,800,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,780,000.00	9,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	800,000.00
210604	Урсгал засвар	12,409,000.00	4,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,200,000.00	8,988,000.00
210702	Дотоод албан томилолт	9,200,000.00	8,988,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,550,000.00	4,292,380.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	220,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	800,000.00	800,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	100,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	500,000.00
210807	Газрын төлбөр	00.00	17,380.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,000,000.00	2,200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,260,000.00	4,999,267.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,760,000.00	2,999,267.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,927,144.00	24,294,328.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,220,400.00	18,685,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,620,400.00	18,085,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,706,744.00	5,609,028.05
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,706,744.00	5,609,028.05
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,315,896.00	108,729,308.58	-23,216,581.68	339828622.9
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-11,961,305.26	11,961,305.26
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,315,896.00	108,729,308.58	-35,177,886.94	327,867,317.64
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,315,896.00	108,729,308.58	-35,177,886.94	327,867,317.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,859,380.97	1,859,380.97
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254,315,896.00	108,729,308.58	-33,318,505.97	329,726,698.61
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	10,094,756.02	10,094,756.02

D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,315,896.00	108,729,308.58	-23,223,749.95	339,821,454.63
-----	--	----------------	----------------	----------------	----------------

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	251,315,000.00	250,368,217.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	251,315,000.00	250,368,217.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	232,629,700.00	231,682,917.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	145,778,000.00	145,777,999.93
210101	Үндсэн цалин	102,805,800.00	102,805,800.00
210102	Нэмэгдэл	39,160,700.00	39,160,699.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,811,500.00	3,811,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,680,100.00	18,837,540.02
210201	Тэтгэврийн даатгал	13,848,900.00	13,006,340.02
210202	Тэтгэмжийн даатгал	1,457,800.00	1,457,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,166,200.00	1,166,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	291,600.00	291,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,915,600.00	2,915,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,938,600.00	22,929,768.00
210301	Гэрэл, цахилгаан	16,916,100.00	11,207,968.00
210302	Түлш, халаалт	3,300,000.00	3,300,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,722,500.00	2,721,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,058,000.00	10,057,963.00
210401	Бичиг хэрэг	1,800,000.00	1,799,963.00
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	5,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	258,000.00	258,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,500,000.00
2105	Нормативт зардал	2,000,000.00	2,000,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,000,000.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,800,000.00	13,800,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	9,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	9,700,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,000,000.00	8,988,000.00
210702	Дотоод албан томилолт	9,000,000.00	8,988,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,375,000.00	4,292,380.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	400,000.00	400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	220,000.00	220,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	800,000.00	800,000.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	100,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	500,000.00
210807	Газрын төлбөр	50,000.00	17,380.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,200,000.00	2,200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5000000.00	4,999,267.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	2,999,267.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18685300.00	18,685,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,685,300.00	18,685,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,085,300.00	18,085,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	600,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	251,315,000.00	250,368,217.95
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	186,315,000.00	185,368,217.95
131001	Улсын төсвөөс санхүүжих	186,315,000.00	185,368,217.95
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	65,000,000.00	65,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,000,000.00	65,000,000.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	13	13
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8
620003	Үйлчлэх ажилтан	4	4

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Нэмэлт санхүүжилтийн дансаар төсвөөс авах авлагаас 630.0 мянган төгрөг төвлөрүүлж, зарлага гаралгүй холбогдох төсөвт төвлөрүүлсэн тул тайлан гаргаагүй байна.

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Ховд аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг [дарга Б. Гомбосүрэн](#) танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн гүйцэтгэл болон авлага, өр төлбөрийн талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 18-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Н.Батжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрхэм зорилго: “Стандартчилал, тохирлын үнэлгээ, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээний баталгаажуулалт, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, сорьцын хяналтын ажлын хүрээг өргөжүүлэх, боловсон хүчний чадавхыг сайжруулах, мэргэшүүлэх, сургалтад хамруулах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлжээ.

Тус хэлтэс нь Монгол улсын “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай”, “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай” хуулиуд болон түүнтэй нийцүүлэн гаргасан Засгийн газрын тогтоол шийдвэр, дүрэм журмын хүрээнд бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, хэмжих хэрэгслийг баталгаажуулах ажлыг өөрийн итгэмжлэгдсэн хэмжилзүйн 5 төрлийн лабораториудад түшиглэн хэрэгжүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Ховд аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Стандарт хэмжил зүйн газар болон аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй байна. Харин төрийн сангийн хяналтыг тухай бүр хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр **нийт зардлыг** сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 292681.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 2926.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 245285.5 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 2452.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Ховд аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12236.9 мянган төгрөгөөр буюу 4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан Авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, хуримтлагдсан үр дүнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
АВЛАГА	12898.7	20448.6	7550.0	59%
БАРАА МАТЕРИАЛ	5159.7	12917.1	7757.4	150%
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	309608.8	306738.5	-3070.3	-1%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	327867.3	340104.2	12236.9	4%
НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	282.8	282.8	100%
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	327867.3	339821.5	11954.1	4%
ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН	-35177.8	-23223.7	11954.1	34%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	327867.3	340104.2	12236.9	4%

Авлага дансны эцсийн үлдэгдэл 20448.6 мянган төгрөг болж 7550.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь цахилгаан зуух сантехникийн засварын ажлын гүйцэтгэл дуусаагүй тул хүлээн аваагүй 5700.0 мянган төгрөг, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тогтоолын дагуу 2026.1 мянган төгрөгийн авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12917.1 мянган төгрөг болж 7757.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хангамжийн материалд 7757.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 309608.8 мянган төгрөг, оны эцэст 306738.5 мянган төгрөг болж 3070.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Энэ бууралт нь урсгал зардлаас худалдан авсан 5900.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэн авсан болон тайлант үеийн элэгдлийн зардал 8970.3 мянган төгрөг бүртгэсэнтэй холбоотой байна. Шинээр худалдан авсан үндсэн хөрөнгийг төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт бүртгүүлэх хүсэлтээ албан бичгээр илгээсэн байна

Тайлант үед үр дүнгийн тайланд нийт 255380.3 мянган төгрөгийн орлого, нийт 245285.5 мянган төгрөгийн зардал тайлагнасан болон өмнөх үеийн алдааны залруулга 1859.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь хуримтлагдсан үр дүн дансыг 11954.1 мянган төгрөгөөр өсгөсөн байна.

Ховд аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 25339.8 мянган төгрөгөөр буюу 9.0 хувиар буурсан байна. Энэ үзүүлэлт нь 52820.5 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт буурсан, өөрийн үйл ажиллагааны орлого 27480.6 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 47395.8 мянган төгрөгөөр буюу 16 хувиар буурсан байна. өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 13983.1 мянган төгрөг буюу 9 хувь, тогтмол зардал 1,463.4 мянган төгрөг буюу 9 хувиар, хангамж бараа материалын зардал 2968.2 мянган төгрөг буюу 32 хувиар тус тус өссөн, эд хогшил урсгал засварын зардал 9087.5 мянган төгрөгөөр буюу 68 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 16458.3 мянган төгрөгөөр буюу 59 хувиар, урсгал шилжүүлэг 40662.8 мянган төгрөгөөр буюу 63 хувиар тус тус буурсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 251315.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 251315.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд 251315.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 186315.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 65000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 186315.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 69032.4 мянган төгрөг, нийт 255347.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 250368.2 мянган төгрөгийг зарцуулж 4,979.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 250368.2 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 65000.0 мянган төгрөгөөс 69032.4 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн нь төлөвлөгөөг 106 хувиар давуулсан байна.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар авлагаар бүртгэсэн 630.0 мянган төгрөг төвлөсөн боловч 630.0 мянган төгрөгийг холбогдох төсөвт татан төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 152 мэдээллээс хугацаандаа оруулсан 115, хугацаа хоцроосон 31, огт мэдээлээгүй 6 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 6 мэдээллийг 6 7 дугаар сараас хойш шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 11121.8 мянган төгрөгийн албан шаардлага, давтан гаргахгүй байх 11379.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж зөвлөмж өгөгдсөнөөс 1 зөвлөмж бүрэн хэрэгжиж, 1 зөвлөмж болон албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн нийт алдаа зөрчилд түүнийг арилгах, давтан гаргахгүй байх 6536.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа: Аудитаар залруулга хийгдээгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил: Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа зөрчил байхгүй болно_

Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн 6536.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

- 1.1. **Илрүүлэлт:** Гэрэл цахилгааны зардлын батлагдсан төсвөөс зарцуулагдаагүй үлдээдлээс цахилгаан халаалтын тогоо болон халаалттай холбоотой засварыг Ланз ХХК-тай 5700.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан хийлгэсэн боловч ажлын гүйцэтгэл дутуу тул гэрээг дүгнэж хүлээн аваагүй зөрчил илэрлээ.
- 1.2. **Эрсдэл:** Төсвийн тухай хуулийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдээдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдээдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 42.3-д “Төсвийн шууд захирагчийн төсөвтөө зохицуулалт хийх асуудлыг дараах байдлаар шийдвэрлэнэ” гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд төсвийн үргүй зардал нэмэгдэх, дотоод хяналт сулрах
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг баримтлан төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажиллах
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

2. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

- 2.1. **Илрүүлэлт:** Санхүүгийн байдлын тайланд нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын тооцоолотой холбоотой үүссэн 553.8 мянган төгрөгийн авлага, нийгмийн даатгалын шимтгэлийг илүү суутгасантай холбоотой хувь хүнд өгөх өглөг 282.3 мянган төгрөгийн бүртгэсэн байна.
- 2.2. **Эрсдэл:** Дотоод хяналт сулрах
- 2.3. **Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хийлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих,


мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэсэн заалтыг баритлан ажиллаж холбогдох тооцоог тухай бүр хий бодож авлага, өглөг үүсгэхгүй байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ



№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Батлагдсан төсвөөс зардлын зүйл хооронд шилжүүлэн зарцуулсан	5700.0	Зөвлөмж өгөх	Дарга , нягтлан бодогч	Б.Гомбосүрэн Б.Баатарсүрэн
2	Тооцооллын зөрүүгээс авлага, өр төлбөр үүсгэсэн	836.6	Зөвлөмж өгөх		
ДҮН		6536.6			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР